



ЗООНОЗЫН ӨВЧИН СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВ

Зоонозын халдварт өвчний долоо хоног тутмын мэдээлэл

Дугаар №28



2019 оны 9 дүгээр сарын 02-06

НЭГ. ТОХИОЛДОЛД СУУРИЛСАН ТАНДАЛТЫН МЭДЭЭ

Улсын хэмжээнд 2019 оны 9 дүгээр сарын 06-ны өдрийн байдлаар ЗӨСҮТ-д зоонозын халдварын хүний өвчлөлийн сэжигтэй байж болзошгүй нийт **933** яаралтай дуудлагыг хүлээн авсан байна. Эдгээрийн 106(11.4%) галзуугийн эрсдэлд өртсөн, 802(86.1%) хачигт халдвар, 6(0.6%) боом, 7(0.7%) тарваган тахал, 2(0.2%) хумхаа, 1(0.1%) ям, 4(0.4%) денги, 4(0.4%) бэтэг, 1(0.1) бруцеллез өвчний сэжигтэй тохиолдол тус тус бүртгэгдсэн байна.

1.1. Галзуу өвчний эрсдэлд өртсөн тохиолдол:



Баянхонгор, Булган, Говь-Алтай, Дорноговь, Дундговь, Завхан, Орхон, Өвөрхангай, Өмнөговь, Сэлэнгэ, Төв, Увс, Ховд, Хөвсгөл, Хэнтий аймгийн 22 сум, нийслэлийн 4 дүүргээс галзуу өвчний эрсдэлд өртсөн нийт 106 тохиолдол бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 2%-иар, эпидемиологийн 35 дугаар долоо хоногтой харьцуулахад 1 тохиолдлоор тус тус нэмэгдсэн үзүүлэлттэй байна.



Галзуу өвчний сэжигтэй зэрлэг, мал амьтанд уруулж, ноцуулан, шүлсдүүлсэн хүмүүсийн тохиолдлыг эх уурхайгаар нь авч үзвэл: эзэнтэй нохойд (39.6%), чононд (17.9%), эзэнгүй нохойд (14.2%), үнэгэнд (9.4%), үхэрт (7.5%), мануулд (2.8%), мууранд (1.9%), тэмээнд (0.9%) нь уруулж, ноцуулж вакцин, ийлдэс эмчилгээнд хамрагдсан байна.

1.2 Хачгаар дамжих халдварт өвчний сэжигтэй тохиолдол:

Архангай, Баянхонгор, Булган, Баян-Өлгий, Дорнод, Дундговь, Дорноговь, Дархан-Уул, Говьсүмбэр, Говь-Алтай, Өмнөговь, Өвөрхангай, Ховд, Хэнтий, Хөвсгөл, Завхан, Сэлэнгэ, Төв, Увс, Орхон, Сүхбаатар аймгийн 116 сум, нийслэлийн 7 дүүрэгт хачгаар дамжих халдварын 802 сэжигтэй тохиолдол бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 25.3%-иар, эпидемиологийн 35 дугаар долоо хоногтой харьцуулахад 9 тохиолдлоор тус тус буурсан үзүүлэлттэй байна.



2019 оны 9 дүгээр сарын 06-ны өдрийн байдлаар ХР-ын 647 сэжигтэй тохиолдлын 118 (18.2%), ХБ-ын 70 сэжигтэй тохиолдлын 13 (18.6%), ХЭ-ын 85 сэжигтэй тохиолдлын 16 (18.8%) нь тархвар судлал, эмнэл зүй, лабораторийн шинжилгээгээр онош батлагдсан.

1.3 Шувууны шалтгаан тодорхойгүй хорогдол:

Завхан аймгийн Дөрвөлжин сумын Онц багийн нутаг “Багануур” гэдэг газар 2019 оны 9 дүгээр сарын 01-03-ны өдрүүдэд олон тооны шувууд шалтгаан тодорхойгүй үхсэн байна.

Авч хэрэгжүүлсэн хариу арга хэмжээ:


- Голомтод Монгол улсын Шадар сайдын 08 дугаар тушаалын хүрээнд Аймгийн Онцгой байдлын газар, сумын ЗДТГ, Завхан аймгийн ЗӨСТ, Тахь хамгаалах хөдөлгөөн, сумын Мал эмнэлгийн алба ажилласан.
- Нийт 15 зүйлийн 1521 шувууг устгасан.
- 2019 оны 9 дүгээр сарын 04-нд үхсэн шалтгаан тодорхойгүй шувуудаас сорьц дээжилж УМЭАЦТЛ-т шинжилгээ хийхэд сөрөг дүнтэй байна. Онош тодруулах шинжилгээ үргэлжилж байна.
- Аймгийн Онцгой комиссын 2019 оны 9 дүгээр сарын 04-ний өдрийн хурлаар голомтод Мал эмнэлэг, Байгаль орчин, Мэргэжлийн хяналтын байгууллагуудыг үргэлжлүүлэн ажиллуулж, бусад салбар хоорондын байгууллагуудыг эргүүлэн татсан.
- Завхан аймгийн ЗӨСТ голомтод ажиллаж буй багийн халдвар хамгааллын байдалд мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч байна.

ХОЁР. ТУХАЙН 7 ХОНОГТ БҮРТГЭГДСЭН ЗООНОЗЫН ШАЛТГААНТ ҮЙЛ ЯВДЛЫН МЭДЭЭ


Олон улсад:

Эбола вируст халдвар:

2019 оны 8 дугаар сарын 29-ний өдрийн байдлаар Бүгд Найрамдах Ардчилсан Конго улсад Эбола вируст халдварын сэжигтэй тохиолдол 2997 тохиолдол бүртгэгдсэнээс 1998 (67%) нь нас барсан. Нийт тохиолдлын 1740 (58%) нь эмэгтэйчүүд, 773 (29%) нь 18-аас доош насны хүүхэд, залуучууд эзэлж байна. Эрүүл мэндийн байгууллагын 156 ажилчид халдвар авсан талаар мэдээлэгдэж байна.



Хүснэгт 1. Эпидемиологийн долоо хоног




Зураг 1. Эбола вируст халдварын тархалт, БНАК улс

Эх сурвалж: ДЭМБ

Мал, амьтны боомын өвчлөл:

Армени улсын Мал, амьтны эрүүл мэндийн газрын мэдээгээр 2019 оны 8 дугаар сарын 29-нд Армавир тосгоны үхрийн аж ахуйд *Bacillus anthracis*-аар үүсгэгдсэн мал, амьтны боомын өвчлөл бүртгэгдэж 10 үхэр өртөмхий байснаас 1 үхэр өвчилсөн байна. Дээрхи тохиолдол нь ДМАЭМБ-ын мал, амьтны өвчлөлийн 2019 оны 9 дүгээр сарын 02-ны өдрийн мэдээнд нийтлэгдсэн байна.



Эх сурвалж: ДМАЭМБ

Африкийн гахайн мялзан өвчин:

Эх сурвалж	Хаана	Мэдээлсэн хугацаа	Өртсөн хугацаа	Нэгж	Өртөмхий	Өвчилж үхсэн	Устгасан
ДМАЭМБ	• Болгар улс • Бургас хот	2019.09.02	2019.08.30	Ойд			1 зэрлэг гахай
ДМАЭМБ	• Словак улс • Кошице тосгон	2019.09.03	2019.08.30	Ойд		1 зэрлэг гахай	
ДМАЭМБ	• Унгар улс • Хэйвэс тосгон	2019.09.03	2019.08.27	Ойд		1 зэрлэг гахай	
ДМАЭМБ	• Молдав улс • Гахул тосгон	2019.09.04	2019.08.05	Тодорхойгүй	6 гахай	1 гахай	5 гахай
ДМАЭМБ	• Хонг Конг • Шэйнг Шуй Шлаугтэрха ус муж	2019.09.04	2019.09.03	Ферм		3 гахай	

Эх сурвалж: ДМАЭМБ